



АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,404.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.	5
ХОЁР. САНГИЙН ЯАМНААС ХЯНАСАН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГЫГ 7,445.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БА БОДИТ ТООЦОО СУДАЛГААГҮЙ, БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА.....	9
ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	13
ДҮГНЭЛТ:.....	18



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрслэл, хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Торгуулийн орлого	8
Дүрслэл 2	Урсгал зардал	11
Дүрслэл 3	Урсгал зардлын бүтэц	11
Дүрслэл 4	Төсвийн харьцуулсан судалгаа	18
Хүснэгт 1	Ус ашигласны төлбөрийн орлого	7
Хүснэгт 2	Аймгийн нийт хүн амд эзлэх төрийн албан хаагчдын хувь	12
Хүснэгт 3	Хөрөнгийн зардлын төсөв	13

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого	6
Хавсралт 2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого	6
Хавсралт 3	Газрын төлбөрийн орлого	7
Хавсралт 4	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашигласны төлбөрийн орлого	8
Хавсралт 5	Торгуулийн орлого	8
Хавсралт 6	Түрээсийн орлого	8
Хавсралт 7	Нэр заагдаагүй орлого	10
Хавсралт 8	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээ	11
Хавсралт 9	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн орон нутгийн иргэдийн санал аваагүй төсөл, арга хэмжээний жагсаалт	15
Хавсралт 10	Сумдаас санал ирүүлээгүй төсөл арга хэмжээний жагсаалт	16
Хавсралт 11	Зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээ	16
Хавсралт 12	Бодлогын баримт бичигт нийцээгүй төсөл арга хэмжээний жагсаалт	16
Хавсралт 13	Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга хэмжээний жагсаалт	16
Хавсралт 14	Өмнөх шийдвэрийн хэрэгжилт	18



Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн баталсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглүүлсэн эсэхийг үнэлэх, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх дүгнэлт зөвлөмж гаргахад аудитын зорилт чиглэсэн. Үүнд:

- Татварын болон татварын бус орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгаа эсэх,
- Төсвийн төсөлд зарлага бууруулах боломжийг бүрэн тусгасан эсэх,
- Төсвийн төсөлд төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх боломжийг бүрэн тусгасан эсэх,

Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС, Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг гүйцэтгэх заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж гүйцэтгэсэн.

Аудитаар аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан холбогдох бодлогын зорилтын хэрэгжилт, эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хяналт, санхүүгийн үйл ажиллагаа, үр ашигт судалгаа хийх, нэгтгэсэн дүн шинжилгээ, харьцуулалт хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын горимыг хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөр, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын хамарсан
хүрээ

Аудитад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтэс, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон холбогдох бусад байгууллагын аудитын сэдэвт хамаарап бүхий үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Талуудын хүлээх
үүрэг, хариуцлага

Засаг даргаас аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан эсэхэд аудит хийж, Төсвийн тухай хуульд заасан хугацаанд дүгнэлт гаргах нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, эхлах аудитор Д.Цэрэнханд эхэлж, эхлах аудитор М.Атарцэцэг, Н.Гэрэлмаа, аудитор Ц.Сайханжаргал, Э.Сүнжидмаа, С.Санчирмаа, Д.Ганзориг, Б.Батбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн 2023 оны батлагдсан төсвийг 5 удаа тодотгон, орлогыг 20,416.7 сая төгрөгөөр, нийт урсгал зардлыг 44,182.7 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд орлогыг 20,236.3 сая төгрөг байхаар төсөвлөсөн нь 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2,860.7 сая төгрөгөөр буюу 14.1 хувиар өсөхөөр тооцсон байна.

Төсвийн төсөлд урсгал зарлагыг 38,479.8 сая төгрөгөөр төлөвлөж Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд 8,781.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн хянасан байна.

Төсвийн зарлагын дүнг 2024 онд нийт 54,685.3 сая төгрөгөөр төсөвлөсөн нь 2023 оны баталсан төсвөөс 23.7 хувиар, хянагдсан төсвөөс 16.0 хувиар буюу 7,455.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусгасан байна.

Улсын төсвөөс 2024 онд авах санхүүгийн дэмжлэгийг 33,672.0 сая төгрөгөөр тооцсон нь өмнөх онтой харьцуулахад 82.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогын зорилтын хүрээнд орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор 2023 оноос олгож эхэлсэн орон нутгийн нэмэгдлийн хувь хэмжээ болон хамрах хүрээг нэмэгдүүлэх.
- Төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд 1 удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгох.
- Төрийн албан хаагчдын цалинг 2024 оны 4 дүгээр сараас үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх.
- Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолын дагуу Худалдан авах ажиллагааны газрыг байгуулахаар болгосонтой холбоотой 8 орон тоо шинээр нэмэгдэхээр байна.

Орон нутгийн төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын зардалд 8,624.7 сая төгрөгийн 93 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс шилжих 1,475.1 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 75 төсөл, арга хэмжээг тусгасан байна.



НЭГ. ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ 1,404.9 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА.

1.1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг 20,236.3 сая төгрөг байхаар төлөвлөсний 92.6 хувийг буюу 15,875.9 сая төгрөг нь татварын, 7.4 хувийг буюу 1,492.8 сая төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлэхээр тооцжээ.

1.2. Орон нутгийн төсвийн орлогын төсөөллийг 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 2,860.7 сая төгрөгөөр өсөхөөр тооцсон нь ахуйн нэгжийн орлогын албан татвар, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, газрын дуудлага худалдааны орлого, хүүгийн орлогыг өмнөх оноос нэмэгдүүлэн төлөвлөснөөс голлон шалтгаалсан байна.

1.3. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогоос 265.0 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ.

1.4. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹-д заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 60 дугаар тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг тогтоосон байна. Өмнөх оны татварын бааз сууриар тооцоход 21.6 сая төгрөгөөр үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг нэмэгдүүлэх боломж байна. */Хавсралт №1/*

1.5. Сангийн яамнаас түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлогыг 41.2 сая төгрөгөөр хянасан байна.

1.6. Төсвийн төсөлд 2024 онд хэрэгжих Дэлгэр сумыг хатуу хучилттай авто замтай холбох замын эхлэл, Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны уулзвар хүртэлх авто замын ажил, аймгийн төвийн хатуу хучилттай 25.6 км авто замын ажилд элс, хайрганы хольцыг ашигласны төлбөрөөс төвлөрөх орлогыг 100.0 сая төгрөгөөр тооцоолон төлөвлөжээ.

1.7. Харин барилга, байгууламж барихад ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны орлогыг тооцож төлөвлөөгүй байна.

1.8. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас 2024 онд шинээр барих барилга байгууламж, түүнд ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын мэдээллийг авч, тооцоход 23.9 сая төгрөгийн орлогыг нэмж төвлөрүүлэх боломж байна. */Хавсралт №2/*

1.9. Төсвийн төсөлд газрын төлбөрийн орлогыг бааз сууриар тооцоолоогүй, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн 480.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

1.10. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын судалгаанд үндэслэн давтан тооцоолоход газрын төлбөрийн орлогыг 321.5 сая төгрөг, өмнөх онуудын газрын төлбөрийн өр 505.3 сая төгрөг, нийт 826.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр байна. */Хавсралт №3/*

¹ Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн хөрөнгийн байршил, зориулалт, хэмжээ, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан 0.6-2.0 хувиар тооцож ногдуулна



1.11. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтад ТЕЗ нарын 2024 оны хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын шалгуур үзүүлэлтэд өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалтыг 70.0 хувьд хүргэхээр баталсан байна.

1.12. Дээрх хавсралтын дагуу газрын төлбөрийн өр 505.3 сая төгрөгийг 70.0 хувиар тооцож үзвэл 353.7 сая төгрөг байна.

1.13. Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам"-ын 12.2-т "Аймаг, нийслэл, чөлөөт бүс тус бүр төрийн сангийн газрын биржийн тусгай данстай байх бөгөөд уг дансанд дуудлага худалдааны орлого, дэнчинг төвлөрүүлнэ" гэж заасан байна.

1.14. Гэвч төсвийн төсөлд газрын дуудлага худалдааны орлогыг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр төлөвлөсөн байна.

1.15. Төсвийн төсөлд газрын дуудлага худалдааны орлогыг 500.0 сая төгрөгөөр төсөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 219.9 сая төгрөг буюу 1.8 дахин, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлтэй харьцуулахад 325.6 сая төгрөг буюу 6.7 дахин нэмэгдүүлж төлөвлөсөн нь газрын дуудлага худалдааны төлбөрийн орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэлтэй байна.

1.16. Ус ашиглалтын төлбөрийн орлогын төлөвлөгөө 2021 онд 43.6 сая төгрөг, 2022 онд 54.1 сая төгрөг, 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 40.5 сая төгрөгөөр тасарсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт №:1 Ус ашигласны төлбөрийн орлого	/сая төгрөг/		
Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү /давсан -, тасарсан +/
2021 он	164.0	120.4	43.6
2022 он	182.8	128.7	54.1
2023.10.30-ны байдлаар	323.6	283.3	40.5

Эх сурвалж: Аймгийн 2021, 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэл

1.17. Ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлтийг хийхдээ үйлдвэрлэл үйлчилгээний 8, дулаан хангамжийн 7, уул уурхайн 8, нийт 23 хуулийн этгээдийн ус ашигласны төлбөрийн орлого 16.7 сая төгрөгийг орон нутгийн төсвийн төсөлд төлөвлөөгүй байна. /Хавсралт №4/

1.18. Төрийн аудитын байгууллагаас 2018 онд хийсэн "Аймгийн хэмжээний усны эрэлт, нийлүүлэлт, хөрөнгө оруулалтын өнөөгийн үнэ цэнэ" гүйцэтгэлийн аудитаар Цагаан марбл ХХК, Алтайн хүдэр ХХК, "Мандал голомт" ХХК-тай холбоотой 67.7 сая төгрөг, 2023 онд "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитаар 15 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой 29.6 сая төгрөгийн ус ашигласны төлбөрийг нөхөн төлүүлэхээр өгсөн шийдвэрийн дагуу нийт 97.3 сая төгрөгийн орлогыг нэмж тооцохоор байна.

1.19. Барилга байгууламж барих, хоол үйлдвэрлэл, халуун ус, үсчин, машин угаалгын үйлчилгээ эрхэлж буй ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн ус ашигласны төлбөрийн орлогыг ногдуулж төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.



1.20. Сангийн яамнаас хянасан торгуулийн орлогын төлөвлөгөөг 100.0 сая төгрөгөөр бууруулж, 1,000.0 сая төгрөгөөр төлөвлөжээ.



Эх сурвалж: Аймгийн 2021, 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэл

1.21. Сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцоолоход торгуулийн орлогыг 286.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна. /Хавсралт №5/

1.22. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5²-д заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” зааврын дагуу түрээсийн орлогоос орон нутгийн төсөвт төвлөрүүлэх дүнг аудитаар давтан тооцооллоо.

1.23. Нийт 29 иргэн, аж ахуйн нэгжид түрээслүүлсэн төрийн байгууллагуудын 11 байр, талбайн түрээсийн орлогыг “Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх” журмын дагуу тооцвол 8.5 сая төгрөгөөр нэмж төвлөрүүлэхээр байна. /Хавсралт №6/

1.24. Мөн “Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар, барилга, тээврийн хэрэгслийн ашиглалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар 0.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт тогтоосон.

1.25. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 56 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх” журмыг шинэчлэн баталж, орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх, түрээсийн гэрээний загвар, төлбөрийн доод үнийг тогтоосон боловч түрээсийн гэрээг шинэчлэн байгуулаагүй нь түрээсийн орлогыг бодитой үнэн зөв төлөвлөөгүйг харуулж байна.

1.26. Өмч хувьчлалын орлогын төлөвлөгөөнд 3 барилгын худалдан борлуулах доод үнийг үлдэгдэл өртгөөр, 13 автомашиныг худалдан борлуулах доод үнийг тогтоолгүйгээр төлөвлөсөн байна.

² Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна



1.27. Энэ нь “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйл заалттай нийцэхгүй байна.

1.28. Иймд 3 барилгыг худалдан борлуулах доод үнийг зах зээлийн бодит үнэ цэнтэй уялдуулах, 13 автомашины худалдан борлуулах доод үнийг тогтоож орлогыг төлөвлөх шаардлагатай байна.

1.29. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 33 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй граж агуулахын барилгыг хувьчлахаар шийдвэрлэсэн боловч Хүрийн овоо ХХК-тай 2024 оны 02 дугаар сар хүртэлх хугацаанд түрээслэхээр гэрээтэй байна.

1.30. Байгаль орчин, аялал жуулчлалын газраас тусгай болон ахуйн зориулалтаар агнах, барих ангийн тоо хэмжээ, нийт 505.2 сая төгрөгийн төлбөрийн саналыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2023 оны 10 дугаар сард хүргүүлсэн байна.

1.31. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ан амьтан агнах, барих тоо хэмжээг баталж ирүүлээгүй тул орон нутгийн төсвийн төсөлд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын саналыг 50.0 хувиар буюу 252.6 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна.

1.32. УИХ-ын гишүүдийн төсвийн багцаас 2009-2012 онд олгосон жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор иргэд, хоршоо, аж ахуй нэгжид олгосон хугацаа хэтэрсэн зээлийн 409.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

1.33. Дээрх зээлийн үлдэгдлээс Шүүхийн шийдвэр гарч хуваарийн дагуу төлөгдөх 122.5 сая төгрөгийн нэр заагдаагүй орлого 2024 онд төсөвт нэмж төвлөрүүлэх боломжтой байна.
[/Хавсралт№7/](#)

1.34. Төсвийн тухай хуульд 2020 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр тухайн аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тусгасан байна.

1.35. Аж, ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлөвлөхдөө Сангийн яамны хянасан дүнгээс 710.0 сая төгрөг буюу 3.4 дахин, 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 750.0 сая төгрөг буюу 4 дахин нэмэгдүүлсэн нь бодит судалгаа тооцоололгүй, үндэслэлгүй байна.

1.36. Татварын ерөнхий газраас орон нутагт аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг хуваарилахдаа тухайн аймгийн татвар төлөгчдийн цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн и баримтын дүнд үндэслэн шилжүүлдэг байна.

1.37. Аймгийн хэмжээнд татвар төлөгчид цахим төлбөрийн баримтын системд бүртгүүлсэн и баримтын дүн бусад аймгуудтай харьцуулахад улсын дунджаас 3 дахин бага байна.

1.38. Иймд татвар төлөгчид татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгүүлэх, цахим төлбөрийн баримт олгох, хяналтыг сайжруулснаар орлого нэмэгдэх боломж байна.



1.39. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татварыг Сангийн яам 9,528.0 сая төгрөгөөр хянасан байна.

1.40. Аймгийн Татварын хэлтсээс тус орлогыг 2024 онд 10,599.9 сая төгрөгөөр тооцоолон төвлөрүүлэх боломжтой гэж үзсэн байна.

1.41. Гэтэл орон нутгийн төсвийн төсөлд 14,137.3 сая төгрөг буюу 4,137.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсөвлөсөн нь төлөвлөгөө биелэгдэхгүй байх эрсдэлтэй байна.


1.42. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд татварын болон татварын бус орлогыг төвлөрүүлэх үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудын мэдээллийн бааз суурийг үндэслээгүй, орлогын мэргэжилтэнгийн судалгаанд үндэслэн боловсруулсан байна. Тухайлбал: Газрын дуудлага худалдаа, сонгон шалгаруулалт, хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, түрээсийн орлого, нэр заагдаагүй орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар.

ХОЁР. САНГИЙН ЯАМНААС ХЯНАСАН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГЫГ 7,445.5 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЖ ТӨЛӨВЛӨСӨН БА БОДИТ ТООЦОО СУДАЛГААГҮЙ, БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ БАЙНА.

2.1. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагын дүнг 2023 оны тодотгосон төсвөөс 21,387.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 54,685.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнд: Урсгал зардалд 53,060.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,624.7 сая төгрөгийг зарцуулахаар тус тус төлөвлөсөн байна.

Дүрслэл №2: Урсгал зардал


/сая төгрөг/



2.2. Төсвийн урсгал зардал 2018-2022 оны гүйцэтгэлээр дунджаар 17 хувийн өсөлттэй байсан бол 2024 оны төсвийн төслөөр 2023 оны тодотгосон төсвөөс 60.8 хувиар нэмэгдэхээр байна.



Дүрслэл №3: Урсгал зардлын бүтэц /сая төгрөг/



2.3. Урсгал зардлын бүтцийг авч үзвэл бараа үйлчилгээний зардалд 39.9 хувь, цалин хөлс, шимтгэлийн зардалд 63.1 хувийг зарцуулахаар байгаа нь 2023 оны тодотгосон төсвөөс 92.0 хувиар өссөн байна.

2.4. Аймгийн 2024 оны төсвийн төсөлд цалингийн зардлыг 18,795.3 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийг 2,403.1 сая

төгрөгөөр төсөвлөсөн. Аудитаар түүвэрлэн үзэхэд сумдын ЗДТГ-ын цалингийн ангилалыг 6.7 сая төгрөгөөр, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГ, Санхүүгийн хяналт аудитын алба, Худалдан авах ажиллагааны газар, Сум дундын ойн ангийн цалингийн ангилалыг 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй тооцсон байна.Тухайлбал:

- Санхүүгийн албаны даргыг ТЗ-5 ангилалаар
- Архив бичиг хэргийн ажилтныг ТҮ-4, ТҮ-3, ТЗ-9 ангилалаар
- Жолооч ТҮ-1 ангилалаар
- Үйлчлэгч ТҮ-2 ангилалаар
- Нярав ТҮ-5 ангилалаар

Хүснэгт№2: Аймгийн нийт хүн амд эзлэх төрийн албан хаагчдын хувь

Он	Хүн амын тоо	Төрийн албан хаагчийн тоо	Эзлэх хувь
2020 он	57,911	4,561	7.88
2021 он	58,539	4,652	7.95
2022 он	58,496	4,873	8.33

Эх сурвалж: Аймгийн статистик мэдээллийн эмхэтгэл 2020-2022

2.5. Сангийн яамнаас төсвийн суурь зарлагыг 47,229.7 сая төгрөгөөр хянасан бөгөөд төсвийн төсөлд 7,455.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 54,685.4 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

2.6. Сумдын 100 жилийн ойд 1,400.0 сая төгрөг, боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт 1,000.0 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1,140.0 сая төгрөг, Тусгай сангийн санхүүжилт 627.0 сая төгрөг, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэхэд 500.0 сая төгрөг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх зардалд 80.7 сая төгрөг, малжуулах арга хэмжээнд 100.0 сая төгрөг, аймгийн ЗДТГ-ын эд хогшил урсгал засварын зардалд 485.0 сая төгрөгийг тус тус Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2.7. Аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийн зорилт, хүрэх үр дүн шалгуур үзүүлэлтийг тусгасан боловч хөтөлбөрт зарцуулах төсөв, тоо хэмжээг тодорхойлоогүй байна.

2.8. Урсгал зардлын төсвийн төсөлд 46.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл, арга хэмжээг тусгаж төлөвлөсөн байна. Үүнд:

- Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид 25.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж
- Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд 21.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж.



2.9. Бусад бараа үйлчилгээний зардлаас 45.1 сая төгрөгийн тэвчиж болох зардлуудыг бууруулах боломжтой байна. Үүнд: Сумдын ЗДТГ-ын хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 24.1 сая төгрөгөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 3.8 сая төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 17.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төсвийн төсөлд тусгасан.

2.10. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7, 15 дугаар зүйлийн 15.2.3³ дахь заалтуудыг зөрчсөн байна.

2.11. Төсвийн эрх захирагчдын саналд үндэслээгүй, төсвийн хязгаарт тусгаагүй, тооцоо, судалгаагүй 2,110.0 сая төгрөгийн зардлыг төсөвлөсөн байна.

2.12. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор зардлуудыг хэрэгцээ, шаардлагад үндэслэн эрэмбэлэн төлөвлөх шаардлагатай байна.

2.13. Сангийн яамнаас ирүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн төсөл боловсруулж батлуулах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлд Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвийн байр ашиглалтын зардлыг орон нутгийн төсвийн суурь зардалд нэмж тусгасан байна.

2.14. Дээрх байгууллагуудаас 2024 онд 1,956.5 сая төгрөгийн байр ашиглалттай холбоотой зардал гарахаар саналирүүлсэн боловч судалгаа тооцоололгүйгээр 956.5 сая төгрөгөөр бууруулан 1,000.0 сая төгрөгөөр тусгажээ.

2.15. ТЭЗ-ын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд 8,921.2 сая төгрөгийг Засаг даргын ерөнхий дансаар захиран зарцуулахаар төсөвлөсөн нь тооцоо судалгаагүй, байгууллагаас ирсэн саналд үндэслээгүй бөгөөд ямар төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрхэн зарцуулах нь тодорхойгүй байна. Тухайлбал:

- Сумдын 100 жилийн ойтой холбоотойгоор 1,400.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор тусгасан боловч бодит тооцоо судалгаагүй төсвийн хязгаарт тусгагдаагүй, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд төсөвлөсөн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 500.0 сая төгрөгийг төсөвлөсөн нь тооцоо судалгаагүй, хүрэх үр дүн тодорхой бус, төсвийн хязгаарт тусгагдаагүй.
- Малжуулах арга хэмжээнд 110.0 сая төгрөг, шинээр гэр бүл болсон залуу малчин өрхөд 100.0 сая төгрөгийг тус тус олгохоор төсөвлөсөн нь төсвийн хязгаарт тусгагдаагүй, тооцоо судалгаанд үндэслээгүй.

2.16. Эдгээр хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁴, 14 дүгээр зүйлийн 14.2.1⁵ дахь заалтуудтай нийцэхгүй байна.

2.17. Төсвийн төсөлд хөрөнгийн зардлыг төлөвлөхдөө байгууллагаас ирүүлсэн саналыг 214.7 сая төгрөгөөр бууруулж, 1,052.7 сая төгрөгөөр төсөвлөсөн байна.

³ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

⁴ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁵ жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах





Хүснэгт №3: Хөрөнгийн зардлын төсөв

/сая төгрөг/

Байгууллага	Байгууллагуудаас ирүүлсэн санал	Төсвийн саналд тусгасан	Зөрүү
ЗДТГ	1,142.3	917.7	175.0
ИТХ	174.7	135.0	39.7
дүн	1,317.0	1,052.7	214.7

2.18. Сум, байгууллагуудад төсвийг хуваарилахдаа тооцоо судалгаагүйгээр зарим зардлыг ижил дүнгээр хуваарилсан байна. Энэ нь Сангийн яамнаас хянан ирүүлсэн суурь зарлагын хязгаарт багтаан нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн төсвийг сум, байгууллагуудад хуваарилан, төсвийн дараагийн жилд үлдэгдлийг санхүүжүүлэхээр төсөвлөсөнтэй холбоотой байна.

ГУРАВ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОДОРХОЙ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

3.1. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2024 онд 85 төсөл, арга хэмжээг 7,084.7 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс он дамжин хэрэгжих 13 төсөл, арга хэмжээг 1,182.6 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 72 төсөл, арга хэмжээг 5,902.1 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

3.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 1,090.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс он дамжих хэрэгжиж буй 2 төсөл, арга хэмжээг 40.0 сая төгрөгөөр, шинээр хэрэгжих 2 төсөл, арга хэмжээг 1,050.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

3.3. Авто замын сангийн санхүүжилтээр 2024 онд 4 төсөл арга хэмжээг 450.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс өмнөх онд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээс хэрэгжиж үлдэгдэл санхүүжилтийг олгохоор 3 төсөл арга хэмжээг 252.5 сая төгрөгөөр, 197,5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

3.4. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн, зорилго зорилт нь хэмжигдэхүйц байх зарчмыг хангахаар заасан.

3.5. Түүнчлэн Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.1-т "Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна", 31 дүгээр зүйлийн 31.1.2-т "хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх"; Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4-т "ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ" гэж тусгасан.



3.6. Төсвийн тухай хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн "Аймгийн 2024 оны төсвийн төсөл"-д тусгагдсан төсөл, арга хэмжээний хувьд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоогүй байна.

3.7. Төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлэхээр шинээр боловсруулсан төсөл, арга хэмжээний хувьд авч үзэхэд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн 1,750.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл, арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т нийцээгүй. Үүнд:

- "150 мянган айл- орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд түрээсийн орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх-200.0 сая төгрөг,
- "150 мянган айл-орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд төрийн захиргааны албан хаагчдыг орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх-500.0 сая
- "Алтай 80+ хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ-1,000.0 сая төгрөг,
- Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн хил хамгаалах арга хэмжээнд тоног төхөөрөмж худалдан авах-50.0 сая төгрөг.

3.8. Мөн 4,065.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 41 төсөл, арга хэмжээ аймгийн ИТХ-ын 2023 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1,⁶ 6.10.4,⁷ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.1-т⁸ заасан шалгуурыг хангахгүй байна.

/Хавсралт №8/

3.9. Хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг тусгахдаа хууль журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан үзээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаар:

3.10. Тус сангаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2},⁹ 60 дугаар зүйлийн 60.3,¹⁰ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10,¹¹ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны

⁶ "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх";

⁷ "орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх";

⁸ "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх";

⁹ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх:

¹⁰ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно:

¹¹ Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна:



журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1,¹² 4.2-т¹³ заасан шалгуурын хүрээнд авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- "150 мянган айл- орон сууц" үндэсний хөтөлбөр, "Боловсролын чанарыг сайжруулах" хүрээнд төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор урсгал зардлын шинжтэй 4 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,580.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.7.6-т¹⁴ заасантай нийцээгүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл үүсэхээр байна. /Хавсралт №9/
- Аймгийн Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн А/571 дүгээр захирамжаар "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөх, эрэмбэлэх, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлыг хэсгийг байгуулсан байна. Тус ажлын хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө төсөл арга хэмжээг ач холбогдол, тэргүүлэх чиглэлээр нь эрэмбэлээгүй жагсаалтад тусгасан байх бөгөөд багийн Иргэдээс нээлттэй ярилцлага хэлбэрээр санал авч тайлант оны 9, 10 дугаар сард хэлэлцүүлсэн байна. Түүнчлэн урьдчилсан жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар 11 дүгээр сарын 20-ны өдөр хэлэлцүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5,¹⁵ 7.6-д¹⁶ заасан хугацаа болон аймгийн Иргэний танхимаар дамжуулан нээлттэй хэлэлцүүлэг хийх тухай шаардлагыг хангаагүй байна.
- Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 26 нь орон нутгийн иргэдийн санал аваагүй, 19 нь сумдаас дэмжсэн саналгүй, 46 нь зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-т¹⁷ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т¹⁸ 4.1.3-т¹⁹ 4.7.5-т²⁰ заасан шаардлагыг хангахгүй байна. Энэ нь төсөл, арга хэмжээ үр ашиггүй, чанар байдал муутай хэрэгжих эрсдэлтэй байдлыг бий болгож байна. /Хавсралт №10, 11,12/

¹² Аймаг, нийслэлийн түвшинд дараах үндсэн нөхцөлүүдийг хангасан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

¹³ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгагдаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

¹⁴ "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"

¹⁵ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

¹⁶ Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

¹⁷ "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ",

¹⁸ "Сум, дүүргийн иргэдээр дэмжигдсэн сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн жагсаалтад орсон байх",

¹⁹ "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх";

²⁰ "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ";



- "Цээл сумын Ахмадын хороонд тоног төхөөрөмж худалдан авах" төсөл" арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 60.3.2-т²¹ заасан хориглосон зардал байх тул төлөвлөлтөөс хасах нь зүйтэй байна.
- Төсвийн төсөлд тусгасан 3,927.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 20 төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасан аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй байна. Тухайлбал: Төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, Бэлчээрийн болон газар тариалан, хадлангийн зориулалттай худаг гаргах, Багийн төвийн барилгын барих, засварлах хөтөлбөр, арга хэмжээ гэх мэт.
/Хавсралт №13/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаар:

3.11. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т шалгуурын хүрээнд авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- "Дотуур байрны барилга /ГАА, Есөнбулаг сум/" 1,000.0 сая төгрөг, "Халиун сумын цэвэрлэх байгууламжид ЦДАШ татах" 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүд аймгийн ИТХ-ын 2023 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдаагүй, тус ажлын зураг төсөл магадлалаар баталгаажаагүй, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтыг өгөөж, цаашид гарах урсгал зардлын тооцоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29^{1.2.2}²², 29^{1.2.4},²³ 29^{1.2.5}-т²⁴ заасан шаардлагуудыг хангахгүй байна.

Авто замын сангийн санхүүжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний талаар:

3.12. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2}, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан шалгуурын хүрээнд авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- "Цогт сумын жишиг гудамжны өргөтгөл 800м бетон хучилттай зам татах" 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээ нь "Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдаагүй, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, хуульд заасан бусад зөвшөөрөлгүй, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтыг өгөөж, цаашид гарах урсгал зардлын тооцоогүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн

²¹ "улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага";

²² барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

²³ урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

²⁴ тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.



29¹.2.2, 29¹.2.3²⁵, 29¹.2.4, 29¹.2.5, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2,²⁶ 20.3,²⁷ 20.4-т²⁸ заасан шаардлагуудыг хангахгүй байна.

3.13. Иймд дээрх хууль, эрх зүйн актад нийцэхгүй байгаа асуудлуудыг ИТХ-аар хэлэлцэхдээ анхааран үзэж иргэд олон нийтийн саналаар дэмжигдсэн, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий, хуульд заасан тусгай шаардлага хангасан төсөл, арга хэмжээг батлахад харгалзан үзэх шаардлагатай байна.

3.14. Орон нутгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалтын дагуу боловсруулан Сангийн яаманд 38,479.8 сая төгрөгөөр төсөвлөж хүргүүлсэн байна.

Дүрслэл №4: Төсвийн харьцуулсан судалгаа



3.15. Төсвийн хүрээний мэдэгдлээс 2024 оны төсвийн төслийн урсгал зарлагын дүн 16,205.6 сая төгрөгөөр, Сангийн яамнаас хянасан төсвийн дүнгээс 7,455.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсөвлөсөн байна.

3.17. Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан цалин хөлс, шимтгэлийн зардлыг 6,973.5 сая төгрөгөөр, тогтмол зардлыг 3,413.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн, бараа ажил үйлчилгээний хөлсийг 5,305.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төсөвлөсөн

байна.

3.18. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөл боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын /цаашид журам гэх/ 7 дугаар зүйлд заасан 2 шаардлагыг хангахгүй байна гэж дүгнэлээ.

- Эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх.
- Худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаар:

3.19. Төрийн аудитын байгууллага нь Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч

²⁵ техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх

²⁶ Захиалагч нь авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, саадгүй хэрэгжүүлэхэд шаардагдах зураг төсөл, замын чиг /трасс/, геодезийн цэгүүд, газар эзэмшүүлэх зөвшөөрөл зэргийг гүйцэтгэгчид хүлээлгэн өгч, авто замын барилгын ажил явуулах талбайг чөлөөлөх асуудлыг шийдвэрлэсэн байна.

²⁷ Авто зам, замын байгууламжийг барих зорилгоор газар, түүний хэвлийг хөндөхөөс өмнө палеонтологи, археологи, угсаатны зүйн мэргэжлийн байгууллагаар урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.

²⁸ Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг магадлалын дүгнэлт бүхий баталгаажсан зураг төсөлгүй, техник, технологийн хяналтгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.



хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгсөн 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн.
- Аймгийн Засаг даргад 7 зөвлөмж хүргүүлснээс 6 нь хэрэгжиж, 1 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.
- Мөн 1 заалт бүхий албан шаардлага хэрэгжих шатандаа байна. */Хавсралт №14/*

3.20. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 88.5 хувьтай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс болон аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна.

- Татварын болон татварын бус орлогыг 1,404.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
- Сангийн яамнаас хянасан төсвийн суурь зарлагыг 7,445.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн ба бодит тооцоо судалгаагүй, байгууллагын саналд үндэслээгүй байна.
- Төсвийн төслийг хууль тогтоомжид заасан зарчим, шаардлагын дагуу боловсруулах үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээний 56.9 хувь нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
- Төлөвлөсөн хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан тусгай шаардлагыг хангахгүй, хүрэх үр дүн, нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг, өгөөжийг тооцоогүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг татварын бааз сууринд үндэслэн бодитой төлөвлөх.
- Төсвийн төсөлд аймгийн дунд болон хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжид заасан тусгай шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байх.
- Сумдын 100 жилийн ойд зарцуулах төсвийн хөрөнгийг шаардлага хангасан санал, тооцоололд үндэслэн хууль тогтоомжийн хүрээнд төлөвлөх арга хэмжээг авах.
- Анхан шатны нэгж байгууллагуудаас төсвийн төслийг төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн үнэн зөв бодитой боловсруулсан эсэхэд хяналт тавьж ажиллах.
- Төсвийн төслийг хууль, тогтоомжид заасан шаардлага, зарчим, удирамж, аргачлалын дагуу боловсруулан, төсвийн төлөвлөлтийг сайжруулж, судалгаа, тооцоололд үндэслэн бодитой төлөвлөх арга хэмжээ авч ажиллах.

Аймгийн Татварын хэлтэст

- Татварын удирдлагын нэгдсэн системд татвар төлөгчдийг бүртгүүлэх, төлбөрийн баримт олгох ажлыг эрчимжүүлж, тавих хяналтыг сайжруулах.



Орон нутгийн өмчийн газарт

- “Орон нутгийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын дагуу түрээслэгчидтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах.


Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Төрийн аудитын газарт ирүүлэх.

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГО

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	Хөрөнгийн тоо	Ногдуулсан татвар /2021он/	2024 онд төлөвлөсөн	Орлого нэмэгдүүлэх санал
1	Алтай	37	4,450.6	2,100.0	2,350.6
2	Баян-Уул	30	2,082.3	1,500.0	582.3
3	Бигэр	34	5,512.7	5,500.0	12.7
4	Бугат	62	2,630.9	2,300.0	330.9
5	Дарив	37	3,502.7	3,500.0	2.7
6	Дэлгэр	36	3,465.6	1,800.0	1,665.6
7	Жаргалан	53	5,800.0	5,800.0	-
8	Тайшир	39	5,387.3	2,400.0	2,987.3
9	Тонхил	48	5,850.0	5,000.0	850.0
10	Төгрөг	113	1,886.3	1,800.0	86.3
11	Халиун	62	1,568.5	1,200.0	368.5
12	Хөхморьт	50	2,345.6	2,200.0	145.6
13	Цогт	56	3,012.1	2,300.0	712.1
14	Цээл	43	34,978.1	30,000.0	4,978.1
15	Чандмань	69	5,926.8	4,000.0	1,926.8
16	Шарга	41	1,746.8	1,200.0	546.8
17	Эрдэнэ	47	6,701.9	3,400.0	3,301.9
18	Гуулин	8	1,368.7	700.0	668.7
19	Баянтоорой	13	928.8	800.0	128.8
20	Есөнбулаг	778	187,500.0	187,500.0	-
	ДҮН	1,656	286,645.7	265,000.0	21,645.7

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ОРЛОГО

Д/д	2024 онд хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил	ТТММ	Нийт орц /м3/	Нэгжид оногдох татвар /төгрөг/	Аудитын тооцооллоор	2024 оны төсвийн төсөл	Орлого нэмэгдүүлэх санал
1	Сумыг хатуу хучилттай авто замтай холбох замын эхлэл /Дэлгэр сум/	Элс			-		
		Элс, хайрган хольц	40000		40,000.0		
		Хайрга			-		
2	Ентүм зочид буудлаас 3, 4 дүгээр байрны уулзвар хүртэлх авто замын ажил	Элс			-		
		Элс, хайрган хольц	15000	АИТХ-ын 2012 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн 11/06	15,000.0	100,000.0	23,879.6
		Хайрга		дугаар тогтоол 1м3= 1000 төгрөг	-		
3	Аймгийн төвийн хатуу хучилттай 25.6 км авто зам	Элс			-		
		Элс, хайрган хольц	45000		45,000.0		
		Хайрга			-		
4	Барилга, байгууламж	Элс	13130		13,129.5		
		Элс, хайрган хольц	10750		-		
		Хайрга			10,750.1		
Нийт дүн			123879.6	1000	123,879.6	100,000.0	23,879.6


ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ОРЛОГО

/мянган төгрөгөөр/

Д/Д	Сумын нэр	Өмнөх оны үлдэгдэл /Газрын кадастрын системд/			2023 оны бааз сууриар төвлөрөх орлого	2023 онд шинээр олгосон газарт ногдуулах газрын орлого	Орлого нэмэгдүүлэх санал
		2020 он	2021 он	2022 он			
1	Алтай	754.5	1,479.3	1,384.5	633.6	9,700.48	826,867.1
2	Баян уул	1,461.8	1,338.2	1,321.6	9,153.5		
3	Бигэр	346.6	51,544.4	47,062.2	30,454.5		
4	Бугат	1,838.0	2,355.9	2,182.7	14,579.2		
5	Дарив	1,096.3	756.3	852.8	5,087.8		
6	Дэлгэр	4,250.6	9,395.6	2,452.7	19,050.9		
7	Жаргалан	132.1	268.5	626.3	4,184.7		
8	Тайшир	499.2	741.6	1,739.6	42,793.4		
9	Тонхил	532.5	535.1	1,224.0	12,801.6		
10	Төгрөг	341.9	886.5	919.4	63,981.3		
11	Халиун	5,359.5	4,474.4	4,170.8	12,869.8		
12	Хөхморьт	43.7	73.4	116.9	20,398.9		
13	Цогт	338.0	929.7	1,750.4	15,433.0		
14	Цээл	6,375.5	375.6	763.7	167,714.0		
15	Чандмань	62,942.2	49,877.2	74,836.9	91,494.1		
